МЭДЭЭ · 2024 оны 12-р сарын 27

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ӨМГӨӨЛӨГЧӨӨС ГАРГАСАН 314 ГОМДОЛ, ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВСАН



Прокурорын байгууллага 2024 оны 12 дугаар сарын 23-наас 27-ны өдрийг хүртэл хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос гаргасан 314 гомдол, хүсэлтийг шинээр хүлээн авч, нийт 1040 гомдол, хүсэлтийг хяналаа. Хүлээн авсан гомдол, хүсэлтийн дийлэнх нь эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой байна.

Харин шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт шинээр илэрсэн нөхцөл байдлыг шалгуулахаар 1 гомдлыг хүлээн авчээ. Дээрх хугацаанд прокуророос 183 гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн бол одоо 857 гомдол, хүсэлтийг хянаж байна.

Мөн Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингарав, Мишээл салбар дахь "Прокурорын байгууллагын нэг цонхны үйлчилгээ үзүүлэх төв"-үүд 20 иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авч харьяа прокурорын газарт нь шилжүүлж, прокурорын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө мэдээллийг 41 иргэнд өгч ажиллажээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1048